



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

1420: Улсынблагыр хот Сүхбаатар дүүрэг
Жанжин-Д Сүхбаатарын чөлбөй 1, Төрийн ордон
Утас: 26-75-11 Факс: 32-72-16
E-mail: Stateyelectoral@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.03.28. № 13

Г Асуулт тавих тухай Г

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалтад "Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцсан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуултга, асуулт тавьж, хариут хуульд заасан хугацаанд авах" гэж Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хуульчилсан, түүнчлэн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтад Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хуулийн биелэгтийг зохион байгуулж хангах үйл ажиллагааг асуулт тавих байдлаар хэрэгжүүлж болно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.1 дэх хэсэгт "Гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилт, төрийн санхүү, төрийн нийтийн өмч, хүний эрх, эрх чөлөө хангаж байгаа эсэх асуудал болон Улсын Их Хурал бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотой мэдээлэл авахаар тухайн байгууллагын даргад бичгээр хандсаныг "асуулт" гэнэ." гэж тус тус заасны дагуу доор дурдсан асуудлаар мэдээлэл авах зорилгоор Танд хандаж байна.

1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланц дурдсанаар улсын хэмжээнд 4,271 төрийн байгууллагад нийт 228,820 төрийн албан хаагч ажиллаж байна гэсан тоон мэдээлэл байгаа бегеөд 2025 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд хэдэн төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа, тадгээрт ажиллаж буй төрийн албан хаагчдын тоо нэмэгдсэн эсэх талаарх мэдээлэл;

2. Салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар чиг үүргийг нь тодорхойлж, зарим зөвлөл, хороо, төв, комисс зэрэг байгууллагыг Монгол Улсын Засгийн газар, эсхүл тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулж болдог. Төгрөгийн чиг үүргийг нь тодорхойлоогүй, Засгийн газрын гишүүн, яам, агентлагийн чиг үүрэгтэй давхардсан зөвлөл, төв, хороо, комисс зэрэг нэршилтэй байгууллагуудыг байгуулах явдал хавтгайлж. Түүнчлэн тэдгээр байгууллагын албан хаагчид төрийн албаны аль ангилалд хамаарах болон албан тушаалын ангилал, зэрэглэл нь тодорхой бус, төрийн албаны болон бусад сонгон шалгаруулалтаар томилогддог эсэх зргэлзээтэй, цалин халсний хэмжээ нь бусад түрээсэлдэг гэх мэдээллийд гарч байна.

0025000016

Иймд хуулиар чиг үүргийг нь тодорхойлоогүй болон Засгийн газрын гишүүн, яам, агентлагийн чиг үүрэгтэй даахардсан зөвлөл, төв, хороо, комисс зөрөг нэршилтэй хэдэн байгууллага байгаа, тэдгээрт хэдэн албан хаагч ажиллаж байгаа, бүтэц, орон тоо, зохион байгуулалтын чиг үүргийг баталсан шийдвэрүүд, төрийн албаны шалгалт, сонгон шалгаруулалтаар томилогдсон эсэх, тэдгээр байгууллагад олгосон төсвийн хөрөнгө, зарцуулалт, тэр дундаа цалин хөлс болон бусад үйл ажиллагааны зардлын хэмжээний талаарх мэдээлэл;

3.Мен Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь хэсэгт "Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно." гэж, мөн зүйлийн 5.4 дахь хэсэгт "Энэ хуульд зөвсныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалтын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтыг томилох, орон тоог хөвөэр хадгалахыг хориглоно." гэж заасан хэдий ч төрийн өмчит компани, банк, улсын үйлдвэрийн газарт "бүтээмжийн менежер", "хяналтын менежер" гэх нэршил бүхий хэдэн албан тушаалтыг бий болгосон, хэдэн хүн томилогдсон, томилсон этгээдийн шийдвэр, тэдгээрийн цалин хөлс, бусад хангамж, сонгон шалгаруулалтаар томилогдсон эсэх, сонгон шалгаруулалтаар томилогдсон бол холбогдох мэдээллийг бичгээр ирүүлэхийг хүсэж, асуулт тавьж байна.

Иймд төрийн өмчит компани, банк, улсын үйлдвэрийн газарт "бүтээмжийн менежер", "хяналтын менежер" гэх нэршил бүхий хэдэн албан тушаалтыг бий болгосон, хэдэн хүн томилогдсон, томилсон этгээдийн шийдвэр, тэдгээрийн цалин хөлс, бусад хангамж, сонгон шалгаруулалтаар томилогдсон эсэх, сонгон шалгаруулалтаар томилогдсон бол холбогдох мэдээллийг бичгээр ирүүлэхийг хүсэж, асуулт тавьж байна.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

П.САЙНЭОРИГ

Б.ЭНХБАЯР

З.МЭНДСАЙХАН

2225000016